



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/79

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэргэдэх Ахмадын зөвлөлийг байгуулах, зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэргэдэх Ахмадын зөвлөлийг байгуулсугай.

2. Ахмадын зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ахмад настны талаар баримтлах бодлого бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангаж ажиллахыг байгууллагын дэргэдэх Ахмадын зөвлөл /Ж.Оюун/-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Н.Ганболд/-т тус тус даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

133013693

ТӨБЗГ тушаал-/2023

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2023 оны 10 дугаар сарын 10 ны өдрийн
А.Ду дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журам нь цаашид “Журам” гэнэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргыг байгууллагын ахмад настнуудын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэгийг авах, байгууллагаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, эрүүл мэнд, амьдралын идэвхи оролцоог дэмжих үүрэг бүхий Ахмадын зөвлөлийн цаашид “Зөвлөл” гэнэл үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Ахмад настны яс үндэс, нийгмийн гарал, шашин шүтлэг, үзэл бодол, нас хүйс, мэргэжил боловсрол, эрхэлж байсан ажил хөдөлмөр зэргээр үл ялгаварлан ахмад настан бүрт тэгш үйлчлэх зарчим баримтална.

1.3. Ахмадын зөвлөл үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод явуулна.

ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Зөвлөл нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ахмад настны талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангахад чиглэсэн байнгын үйл ажиллагаа явуулна.

2.2. Зөвлөл нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба Зөвлөлийн бүрэлдэхүүнд Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга болон Хүний нөөцийн мэргэжилтэн орох бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүдийн олохийн саналаар сонгож, Газрын даргын тушаалаар батална.

2.3. Зөвлөл өөрийн чиг үүрэгтэй холбоотой асуудлаар хурал зохион байгуулах ба хурлын тов болон хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн дарга тогтоож батална.

2.4. Зөвлөл үйл ажиллагаагаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад жилд 2 удаа танилцуулж байна.

2.5. Зөвлөлийн гишүүдийг 3 жил тутам сэлгэн томилно.

ГУРАВ. ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Зөвлөл нь дараах эрхийг эдлэнэ:

3.1.1. Ахмад настны талаар баримтлах бодлого, холбогдох эрх зүйн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал,

санаачилга гаргах, хууль тогтоомжийн дагуу тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллагад уламжлах;

3.1.2. Ахмад настны талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.3. Ахмад настанд тэтгэмж, тусламж, дэмжлэг олгох, Ахмадын сангийн гүйцэтгэлийг тайлагнах асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын санхүүтэй хамтран хариуцан гүйцэтгэх, хөрөнгийн зарцуулалтад санал оруулах, хяналт тавих;

3.2. Зөвлөл нь дараах үүргийг хүлээнэ:

3.2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран Ахмадын зөвлөлийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулах боломжоор хангах;

3.2.2. Ахмад настнууд ажлын туршлага, ур чадвараараа нэгдэн хоршоо нөхөрлөл байгуулах, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхэд нь төрийн болон төрийн бус байгууллагаас төрөл бүрийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.3. Ахмадын зөвлөлөөс дэмжлэг, тусламж шаарлагатай ахмадуудын судалгааг тогтмол гаргаж, холбогдох дэмжлэгийг үзүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх;

3.2.4. Тэмдэглэлт баярын өдрүүдэд ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг санаачлан зохион байгуулах, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх;

3.2.5. Бусад арга хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран болон дангаар санаачлах, зохион байгуулах.

ДӨРӨВ. ШИЙДВЭР ГАРГАХ

4.1. Зөвлөл гишүүдийн хурлаа жилд хоёроос доошгүй удаа 2/3 ирцтэйгээр хуралдана.


4.2. Зөвлөлийн хурлаас гарах шийдвэрийг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

4.3. Зөвлөлийн хурлын шийдвэр нь тогтоол, тэмдэглэл хэлбэртэй байна. Тогтоолд зөвлөлийн дарга, гишүүд; тэмдэглэлд дарга, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурснаар тус тус хүчин төгөлдөр болно.

4.4. Зөвлөлийн даргын санал болгосноор тухайн асуудлаар санал хураалтыг нууцаар болон илээр хураах зарчмаар шийдвэрлэнэ.

4.5. Зөвлөлийн дарга хэлэлцэж буй асуудлаар гаргасан шийдвэрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагад танилцуулж, салбарын бодлого, шийдвэрт тусгуулах арга хэмжээг авч, үр дүнг тооцно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2023 оны 10 дугаар сарын 10 ны өдрийн
1/29 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДЭРГЭДЭХ АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

- Ж.Оюун – Ахмад настан

Гишүүд:

- Н.Ганболд – Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

- Ч.Алтантуяа – Ахмад настан

- Ц.Отгонбаяр – Ахмад настан

- Н.Дагиймаа – Хүний нөөцийн мэргэжилтэн

.....000.....